
HAN MINING





ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ ХХК

Нүүрс баяжуулах үйлдвэрийн танилцуулга



АГУУЛГА

- КОМПАНИЙ ТАНИЛЦУУЛГА
- ЗОРИЛГО БОЛОН АЛСЫН ХАРАА
- БҮТЭЭГДЭХҮҮН, ГАРЦ
- ДЭД БҮТЭЦ
- КОМПАНИЙ БҮТЭЦ, ЗАСАГЛАЛ

“ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ” ХХК ТАНИЛЦУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН НЭР	"ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ " ХХК
Үйл ажиллагааны чиглэл	▪ Нүүрс боловсруулах үйлдвэрлэл ▪ Автомашинаар ачаа тээвэрлэх үйлчилгээ ▪ Дотоод дахь ажлын зуучлал ▪ Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа ▪ Худалдааны зуучлал ▪ Гадаад худалдаа ▪ Үл хөдлөх хөрөнгийн зуучлал
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 15-р хороо, Хасбаатарын г удамж, 30/1 байр, 5 тоот





ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ ХХК


Эйч Эй Эн Майнинг ХХК Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс урагш 6 км-т, Ухаа худагийн уурхайгаас баруун зүгт 5-т, Эрдэнэс таван толгойн уурхайгаас баруун зүгт 9 км-т оршино. Компани нь “Таван толгой”-н нүүрсний уурхайг түшиглэн түүхий нүүрсийг баяжуулж, баяжмал буюу коксжих чанарын нүүрс гарган авах жилд 2000.0 мянган тонн нүүрсний хүчин чадалтай үйлдвэр юм.


Техник Эдийн Засгийн Үндэслэл :
2022 оны 3 дугаар сарын 22-ны Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн No:Г/22-03-10 батлагдсан ТЭЗҮ-тэй.

Үйлдвэр нь 2025 оноос үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөл дотоодын угаан баяжуулах ажил үйлчилгээ эрхэлэн 2026 оноос нүүрс экспортоо эхлүүлэн ажиллаж байна.

ЗОРИЛГО БОЛОН АЛСЫН ХАРАА

- Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж Монголдоо тэргүүлэх нүүрс баяжуулах үйлдвэрийн нэг болох;
- Дэлхийн жишигт нийцсэн нүүрс баяжуулах технологийг нэвтрүүлэх;
- Байгаль орчны стандартуудыг мөрдөх, учирч болзошгүй хор нөлөөллийг бууруулах.
- Технологийн шинэчлэл тогтмол хийж, нүүрс баяжуулалтын тоо хэмжээг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг нэн тэргүүнд тавих;
- Байгалийн баялагийг зөв зохистой ашиглаж, хаягдалгүй эцсийн бүтээгдэхүүн гарган авах;
- Хөдөлмөр эрхлэлтийн тэгш боломжоор хангаж, ажилтан төвтэй хариуцлагатай ажил олгогч байх;





HAN MINING

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

Нүүрс баяжуулах үйлдвэр нь Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн жилдээ 2.0 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтайгаар байгуулагдаж байгаа ба таван толгойн нүүрсний уурхайн нүүрсний нөөц баяжуулах үйлдвэрийг тасралтгүй хангах бололцоотой.

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	**1 жилд- 2000.0 мян.тонн** **1 сар- 187,500 тонн**
Баяжуулах үйлдвэрийн ажиллах хугацаа	1 жилд- 320 хоног 1 жилд- 7,680 цаг
Баяжуулах арга технологи	Хүнд орчны баяжуулалт, TBS баяжуулалт
Бүтээгдэхүүний гарц	Баяжуулсан нүүрс нь 62.33 %-ийн гарцтай, 10.1 %-ийн үнслэгтэй, 0.81 %-ийн хүхэртэй бүтээгдэхүүн байна. Завсрын бүтээгдэхүүн нь 16.69 %-ийн гарцтай, 23.89 %- ийн үнслэгтэй, 1.11 %-ийн хүхэртэй, хаягдал нь 20.98 %-ийн гарцтай 47.31 %-ийн үнслэгтэй, 4.48 %-ийн хүхэртэй байна.

HAN MINING

НБҮ-ИЙН ДЭД БҮТЭЦ

“ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ ” ХХК нь үйлдвэрийн зориулалт бүхий 16 га талбайтай. 50 ажилтны супер доторлогоо бүхий контэйнер хаус кемптэй.






HAN MINING

НБҮ-ИЙН ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж	Тавантолгой дэд станцийн төвийн эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагддаг. Жилд дунджаар 4000Квт цахилгаан эрчим хүчний хүчин чадал тай . Техникийн комисс ажилласан.
Усны эх үүсвэр	Үйлдвэр ашигласан усаа 95% хүртэл эргүүлэн ашиглах боломжтойгоос гадна гүний 2 худагтай. Энэ нь шаардлагатай тохиолдолд технологийн усыг бүрэн хангадаг.
Дулаан хангамж	Нам даралтын зуух болон цахилгаан үүсгүүр
Зам тээвэр	Гашуун сухайт чиглэлийн 245км авто замтай. Мөн Гашуун сухайт чиглэлий н төмөр зам 2022 онд ашиглалтанд орсон.

HAN MINING

КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



HAN MINING

МАШИН МЕХАНИЗМ, ТЭЭВЭР

“ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ ” ХХК нь үйлдвэрийн тээвэр болон үйл ажиллагаанд бэлэн 4 ковш, 1 эксватор болон гэрээт байгууллагын 10 өөрөө буулгагч машин механизмтэй. Үйлдвэр эхлэхэд шаардлагатай хүний нөөц, ажиллах хүчний бэлтгэл ажлыг 100% хангасан.








ХАМТЫН АЖИЛЛАГАА

“ЭЙЧ ЭЙ ЭН МАЙНИНГ ” ХХК болон "Саусгоби даймонд“ ХХК нь 2025 оны 6 сарын 7-наас нүүрс угаан баяжуулах ажил үйлчилгээний гэрээ байгуулан одоог хүртэл хамтран ажиллаж байна.

2026 оноос Энержи Ресурс ХХК-ын Ухаа худгын уурхайгаас нүүрс худалдан авч үйлдвэртээ угаан баяжуулж экспортод гаргахад бэлэн болсон байна.



Түүхий нүүрс боловсруулах ажил гүйцэтгэх гэрээ

2025 оны 6-р сарын 07 Гэрээний дугаар:20250001 Улаанбаатар хот

Нэг талаас "Саусгоби даймонд" ХХК /РД: 3616703, цаашид "А тал" эсвэл "Захиалагч" гэх/ , нөгөө талаас "Эйч Эй Эн Майнинг" ХХК /РД: 6206689, цаашид "Б тал" эсвэл "Гүйцэтгэгч"/ хамтад нь /"Талууд" гэх/ даравч гэрээг харилцан тохиролцож байгуулав.

Нэг: Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь А болон Б талуудын хоорондын гэрээний харилцааг зохицуулах, А талаас ойролцоох уурхайгаас нийлүүлэх түүхий нүүрсийг Б талд угаан баяжуулах (цаашид " ажил" гэх) үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд энэхүү гэрээнд заасан баяжуулах ажлын хэлс болон бусад ажлын хөлсийг төлбөрийн нөхцлийн дагуу А тал нь Б талд төлберийг хийхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцаа, талуудын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулна.

1.2 Гэрээний хугацаа: Энэхүү Гэрээ нь 2025 оны 6 дугаар сарын 07-ний өдрөөс 2027 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийг дуусах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 Түүхий нүүрс баяжуулах үйл ажиллагааны хамрах хүрээ: Түүхий нүүрсийг жинлэж үйлдвэрт оруулснаас эхлэад талбайд овоолох, нүүрсийг угааж боловсруулах, нүүрсний чанарын шинжилгээ хийх, буулгах, ачих, хаягдал тээвэрлэх зэрэг үйл ажиллагааг хамарна.

Хоёр. Төлберийн нөхцөл

2.1 А талын шинжилгээний шаардлага хангасан тохиолдолд, 1 тонн түүхий нүүрс угааж баяжуулах, буулгах, ачих, хаягдал тээвэрлэх Ажлын хөлсний нэгж үнэлгээ нь доор заасны дагуу тооцож төлнө. Үүнд:


Нүүрс угаан баяжуулах ажлын хөлс 1 тонн тутам (НӨАТ орсон)	Нүүрс буулгах ажлын хөлс 1 тонн тутам (НӨАТ орсон)	Нүүрс ачих ажлын хөлс 1 тонн тутам (НӨАТ орсон)	Хаягдал тээвэр 1 тонн тутам (НӨАТ орсон) (10км хаягдлын далан хүртэлх тээвэр)
5.5 ам.доллар	0.14 ам.доллар	0.21 ам.доллар	2.51 ам.доллар

2.2 Ажлын хөлсийг сараар тооцон Гэрээний 2.1-д заасан үнийн дүнгээр төлберийн тухайн сарын сүүлийн өдрийн Монгол банкны ханшаар тооцон тогтоогөөр төлөх бөгөөд сар бүрийн ажлын хөлс болон бусад тооцоог Б талаас үйлдсэн актын дагуу талууд дараа сарын 3-ны өдрийн дотор тооцоо нийлэн хамтран дүгнэж батлагаажуулан,шаардлага хангасан НӨАТ-н баримтыг Б талаас А талд гаргаж өгнө. А тал нь НӨАТ-н баримтыг хүлээн авсан өдрөөс 5 хоногийн дотор Б талын Худалдаа Хөгжлийн Банкны MN09 0004000 417080785 дансанд тухайн сарын Ажлын хөлс болон бусад ажлын хөлсийг төлнө.

2.3 Төлберийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хоцорсон хоног бүр өдрийн 0.1 хувийн алданги тухайн тооцоо нийлсэн актын үнийн дүнгийн гүйцэтгэгүй үнийн дүнгээр тооцно.

Гурав. А талын эрх, үүрэг

3.1 Б тал нь түүхий нүүрсийг баяжуулах, угаах ажлыг А талын шаардлагын дагуу гүйцэтгэнэ. А тал нь





HAN MINING

ХАЯГ: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс Оффис, 13 давхар
ХАЯГ: “ХАН МАЙНИНГ” Нүүрс баяжуулах үйлдвэр, 3-р баг, Цогтцэций сум, Өмнө говь аймаг, Монгол Улс

УТАС: 98115885
ИМЭЙЛ: hanmining2019@gmail.com